



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/103

Алтанбулаг

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6 "а", Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Загд зүсэм" ХХК-ний "Ундрах маркет" дэлгүүрийн тамхи худалдах тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгосугай.

2. Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл авсан "Загд зүсэм" ХХК-ний "Ундрах маркет" дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумын Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч (Г.Энхтүвшин), Байгаль орчин хяналтын улсын байцаагч (С.Мөнхзул), 1 дүгээр багийн Засаг дарга (Б.Баттулга), Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Б.Одмаа) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (Д.Амартүвшин)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ОТГОНЦОГТ